



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 94


Улаанбаатар хот

Г “Мандал женерал даатгал” ХХК-д жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12¹.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 302 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”-ын 4.1. дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Мандал женерал даатгал” ХХК-д жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.
2. Даатгуулагчийн хууль ёсны эрх ашгийг дээдэлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Мандал женерал даатгал” ХХК /М.Давааням/-д үүрэг болгосугай.
3. Салбараа нээгээгүй аймагт жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагааг аливаа хэлбэрээр эрхлэн явуулахыг “Мандал женерал даатгал” ХХК-д хориглосугай.
4. Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомж, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, “Мандал женерал даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан албан журмын даатгалын хэлбэрийг нэмж бүртгэхийг Тамгын газар /Д.Нямцэрэн/-т тус тус даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН